



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (518)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Транс Азийн төмөр замын сүлжээний тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны арваннэгдүгээр сарын 7

№41 (518)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

523.	Барааг түр хугацаагаар оруулах тухай конвенцийн В-3, С хавсралтад нэгдэн орсныг соёрхон батлах тухай	1025
524.	Монреалын протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсныг соёрхон батлах тухай	1026
525.	Транс Азийн төмөр замын сүлжээний тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай	1026

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

526.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 257	1026
527.	Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай	Дугаар 264	1028
528.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 266	1030
529.	Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай	Дугаар 270	1030
530.	Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 279	1031
531.	Журам батлах тухай	Дугаар 280	1032

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

532.	Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 40	1033
533.	Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар	Дугаар 41	1034

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### БАРААГ ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН В-3, С ХАВСРАЛТАД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Стамбул хотноо 1990 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталсан Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын 1990 оны конвенцийн В-3, С хавсралтад Монгол Улс нэгдэн

орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНРЕАЛЫН ПРОТОКОЛД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай 1987 оны Монреалын протоколд Бээжин хотноо 1999 онд болсон 11 дүгээр хуралдаанаас оруулсан нэмэлт,

өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

### ТРАНС АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Транс Азийн Төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг Монгол Улсын

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын төрөөс хун амын талаар баримтлах бодлого"-ын 3.1.8, Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүлийн тухай хуулийн 10.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Угийн бичиг хөтлөх журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2009 оны төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт тус тус даалгасугай.

1. "Угийн бичиг хөтлөх журам"-ыг хэвсрэлтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Угийн бичиг хөтлөх журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэвсрэлт

### УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасан гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, үгийн бичиг хөтлөх Монгол Улсын иргэний

үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Монгол Улсын иргэн бүр "Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар"-ыг баримтлан өөрийн

\*Энэ загварыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

ураг төрлийн хамаатлын хүрээгээ тогтоож, үр удамдаа заавал өвлүүлдэг үүрэг хүлээнэ.

1.3. Монгол Улсын иргэн бүр угийн бичгээ үндэслэн аливаа хэлбэрийн төрөл ойртсон гэрлэлтээс зайлсхийх, эрүүл саруул удамтай байхын төлөө тэмцэх явдал нь монгол хүний хөгжилд оруулж байгаа үнэт хувь нэмэр мөн.

1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.

## Хоёр. Овог хэрэглэх

2.1. Монгол Улсын иргэн бүхэн өөрийн овогтой байна.

2.2. Монгол Улсын иргэн өөрийгөө илэрхийлэх аливаа баримт бичигт эцгийн овгийг хэрэглэнэ. Гэр бүл болох тохиолдолд эцэг, эхийн овгийг адил эрхтэйгээр тооцно.

2.3. Өвөг дээдсээсээ уламжлан ирсэн эцгийн овгийг мэддэг хүмүүс түүнийгээ шууд хэрэглэнэ.

2.4. Өөрийн эцгийн овгийг мэддэггүй болон бутач, бусдад үрчлэгдсэн хүн эхийн овгийг хэрэглэж болно.

2.5. Эцэг, эхийнхээ овгийг мэддэггүй хүн дор дурдсанаар овог мэдэж хэрэглэнэ:

а/өөрийн сум, аймгийн болон бусад газрын архив хадгалагдаж байгаа нутгийн хүн амын бүртгэл, угийн бичиг, хүмүүсийн намтар зэрэг баримтыг судлах;

б/уугуул нутагт нь хэрэглэдэг овгийн талаар "Овгийн товч намтар"-аас олж тодруулах, тэдгээрээс чухам аль нь өөрийн өвөг дээдсийн болон эцэг, эхийн овог болохыг нутгийн ахмад настан, сайн мэдэх хүнээс лавлан тогтоох; в/энэхүү журмын 2.5-ын "а", "б"-д заасны дагуу овог тогтоох боломжгүй бол өөрийн уугуул нутагт байдаг овогос аль нэгийг үзэмжээрээ сонгон авах

2.6. Энэхүү журмын 2.5-д заасны дагуу овог олж хэрэглэх боломжгүй тохиолдолд дор заасныг үндэслэн зохиомол овог шинээр үүсгэн хэрэглэж болно:

а/тухайн удмын голлон эрхлэж байсан аж ахуй, онгон шүтээн, тамга, эрхэлдэг ажил үйлс, бусдаас ялгагдах өвөрмөц онцлогийг тусгасан нэр бүхий овог үүсгэх (жишээлбэл: Ямаат Болдын Бат, Анчин Сумьяагийн Энхтуяа гэх мэт);

б/төрөл садны холбоотой хүмүүс нутагтаа олны дунд алдаршсан цол, хэргэм зэргийг овог болгох.

в/өөрөө болон өвөг дээдэс нь олон үе нутаглаж ирсэн уугуул газар, уул, усны нэрийг овог болгох (жишээлбэл: Булнайн Доржийн Жав, Сутай Лувсандоржийн Баатархүү, Мэнэн Дашдоржийн Мөнхцэцэг гэх мэт);

г/монголд ястан, угсаатан, үндэстний гаралтай овог байдаг уламжлалын дагуу шинээр овог үүсгэх.

2.7. Зохиомол шинэ овог үүсгэх, эсхүл тухайн нутагт байгаа овогос өөрөө овог сонгосон нөхцөлд төрөл садны холбоотой бүх хүн заавал нэгдмэл байдлаар хэрэглэнэ.

2.8. Хадамд гарсан эмэгтэй уламжлал ёсоор өөрийн овгийг хэрэглэнэ.

2.9. Бутач, өргөмөл, хойд эцэгтэй хүүхдийг төрүүлсэн эцэг буюу эхийнх нь овогтоо овоглоно.

2.10. Монгол Улсын иргэн нь овог хэрэглэсэнтэй холбогдуулан иргэний үнэмлэх, гадаад паспорт, төрсний гэрчилгээ, гэр бүлийн бүртгэл, улсын хэмжээний хүн амын тооллого, бүртгэлийн маягт зэрэг баримт бичигт гурван нэр (овог, эцгийн нэр, өөрийн нэр)-ийг хэрэглэнэ.

## Гурав. Угийн бичиг хөтлөх

3.1. Монгол Улсын өрх бүр угийн бичиг заавал хөтөлнө.

3.2. Өрх бүр угийн бичгээ дор дурдсан дарааллаар бичиг хөтөлнө:

а/өрх бүр эхлээд өөрийн гэр бүлийн бичиглэлээ үйлдэнэ;

б/өөрийн гэр бүлээс төрсөн хүүхэд, тэдгээрээс удамласан бүх гэр бүлийг хамгийн ахмадаас эхлэн үе удмын буурах дарааллыг баримтлан угийн бичиглэлд хамруулна;

в/өөрөөсөө дээшхи үе удмын угийн бичиглэлийг нөхөр, эхнэрийн талаар дээш нь салбарлуулан үе удмын өсөх дарааллыг баримтлан мэдэхгүй үе удмаа хүртэл хөтөлнө.

## Дөрөв. Угийн зураглал хөтлөх

4.1. Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүр хоорондоо цусан төрлийн холбоотой өөрөөс дээш, доош үе удмын ураг төрлийн хамаатлын тухай угийн бичиглэлийг шалгаж нэгдсэн үнэн зөв бичиглэлийг тогтооно.

4.2. Нэгдсэн байдлаар тогтоосон угийн бичгээ "Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар"-т тулгуурлан угийн зураглалын хэлбэрт оруулна.

4.3. Монгол Улсын өрх бүр угийн бичгээ зайлшгүй оруулах мэдээллээр баяжуулан, энэхүү журмын 4.2-т заасан зураглалын хамт хадгалж, үр удамдаа дамжуулан өвлүүлнэ.

## Тав. Угийн бичгийг баяжуулах, овлүүлэх, хэрэглэх

5.1. Монгол Улсын өрх бүр үр хүүхэддээ багаас нь өөрийн гэр бүлийн угийн бичгийг угийн зураглалын хамт таниулан тайлбарлах, зохих мэдлэг олгох үүрэгтэй.

5.2. Монгол Улсын иргэн угийн бичигтээ тулгуурлан гэр бүлээ сонгох зарчмыг мөрдөж, дараахь зүйлийг онцгой анхаарч хэрэгжүүлнэ:

а/эцэг (жишээ нь: олхонууд/ шарнууд), эх (жишээ нь: боржигон/булгудар)-ийн овгуудыг бүрдэхэд аль нэг овог оролцсон хүмүүс хоорондоо үл гэрлэх;

б/угийн бичгээр өөрөөсөө дээш арван үе удмын доторхи ураг төрлийн хамаатлын хүрээгээ тогтоох боломжгүй нэг сум, багийн уугуул иргэд хоорондоо гэрлэхгүй байх зарчим баримтлах, в/өөрийн уугуул сум, багтай хил залгаа зэрэгцээ сум, багийн иргэд хоорондоо гэрлэхгүй байх зарчим баримтлах.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

### Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тавьж, үр дүнг жил бүрийн 3 дугаар сард Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ц.Даваадоржид даалгасугай.

1. Нэг цэгийн үйлчилгээ байгуулах дунд хугацааны хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Нэг цэгийн үйлчилгээ байгуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Ц.ДАВААДОРЖ

Засгийн газрын 2007 оны 264 дүгээр тогтоолын хавсралт

### НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БАЙГУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Өнөөгийн байдал

1. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойши хугацаанд нийгэм дэх төрийн үйлчилгээний хүрээ, нэр төрөл өргөжин төрийн захиргааны байгууллагад үйлчилгээний төвлөрөл, давхардал, шат дамжлага нэмэгдэж, сөрөг үр дагавар бий болж байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 35 дугаар тогтоол гарч иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдэж хууль, бусад эрх зүйн акт амьдралд хэрэгжсэн ч төрийн үйлчилгээ шуурхай бус, шат дамжлага, чирэгдэл ихтэй, хяналтын механизм боловсронгуй бус хэвээр байна.

2. Ийнхүү төрийн үйлчилгээ шат дамжлага, хүнд суртал ихтэй, шуурхай биш, тэгш бус, иргэдэд чирэгдэл учруулж байгаа нь үйлчилгээний хэм хэмжээг зөрчих, улмаар хууль захвруулахад хүргэж, нийгэм, эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө

үзүүлсээр байна. "Нэг цэгийн үйлчилгээ"-г нэвтрүүлэх талаар гарсан Засгийн газрын 2007 оны 3 дугаар тогтоолын дагуу "Нэг цэгийн үйлчилгээ"-ний талаар баримтлах бодлого, авах арга хэмжээг энэхүү дунд хугацааны хөтөлбөрт тусгалаа.

#### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн гол зорилго нь төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа төрөл бүрийн үйлчилгээний шат, дамжлагыг цөөрүүлж, "Нэг үйлчилгээний олон хаалгыг олон үйлчилгээний нэг хаалга"-аар солиход оршино.

4. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилгоор хэрэгжүүлнэ:

4.1. нэг цэгийн үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.2. нэг цэгийн үйлчилгээг аймаг, дүүрэг, суманд үе шаттайгаар зохион байгуулах;

4.3. Нэг цэгийн үйлчилгээний ач холбогдол, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг иргэдэд сурталчлах.

5. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Энэхүү хөтөлбөрийн 4.1 дэх зорилтыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

5.1.1. дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, гэрчилгээ бий болгосон байдлыг судлах;

5.1.2. хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулан боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төсөл боловсруулах;

5.1.3. боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд иргэний нийгэм, хуулийн этгээд, төрийн захиргааны бүх шатны байгууллагаас санал авч хэлэлцүүлэх;

5.1.4. хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

5.2. Энэхүү хөтөлбөрийн 4.2 дахь зорилтыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

5.2.1. нэг цэгийн үйлчилгээг нийслэлийн Сүхбаатар дүүрэгт жишиг байдлаар зохион байгуулах;

5.2.2. нэг цэгийн үйлчилгээг Төв аймгийн Зуунмод хотод жишиг байдлаар зохион байгуулах;

5.2.3. нэг цэгийн үйлчилгээг бусад дүүрэг, аймагт үе шаттайгаар зохион байгуулах;

5.2.4. нэг цэгийн үйлчилгээг суманд нэвтрүүлэх хэрэгцээ, боломжийг судлах, томоохон суманд туршилтын журмаар зохион байгуулах.

5.3. Энэхүү хөтөлбөрийн 4.3 дахь зорилтыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

5.3.1. нэг цэгийн үйлчилгээний зорилго, ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

5.3.2. нэг цэгийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлж байгаа туршлагыг сурталчилж, энэ чиглэлээр гарын авлага гаргаж нэг цэгийн үйлчилгээг хариуцсан ажилтнуудад хүргэх;

5.3.3. нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх талаар төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт, семинар зохион байгуулах.

## Гурав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6. Нэг цэгийн үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөрийг Үйлдвэр, худалдааны яам хариуцна.

7. Нэг цэгийн үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөрийг Үйлдвэр, худалдааны сайд ахалсан Үндэсний хорооны өдөр тутмын удирдлагаар аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

8. Нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулах байр, ажиллах нөхцлийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

9. Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны тогтвортой байдал, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

## Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

10. Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг Швейцарийн хөгжлийн агентлагийн тусламжтайгаар хэрэгжүүлнэ.

11. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

11.1. улсын болон орон нутгийн төсөв;

11.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын дэмжлэг, тусламж;

11.3. гадаадын хөрөнгө оруулалт.

## Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

12. Хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд дараах үе шатаар хэрэгжүүлнэ.

12.1. Хөтөлбөрийн эхний үе шат. 2007 оны 10 дугаар сарын 1-ээс 2008 оны 9 дүгээр сарын 31-ний дотор хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

12.1.1. 2007 оны 10 дугаар сард нэг цэгийн үйлчилгээг нийслэлийн Сүхбаатар дүүрэгт жишиг байдлаар зохион байгуулж, улмаар Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүрэгт байгуулна.

12.1.2. 2008 оны 3 дугаар сард нэг цэгийн үйлчилгээг Төв аймгийн Зуунмод хотод жишиг байдлаар зохион байгуулж, улмаар Дархан, Сүхбаатар, Мандалговь, Даланзадгад, Сайншанд, Баруун-Урт, Чойбалсан, Өндөрхаан, Эрдэнэт болон Чойр хотуудад байгуулна.

12.1.3. нэг цэгийн үйлчилгээний талаархи эрх зүйн болон санхүүгийн орчинг боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ.

12.2. Хөтөлбөрийн хоёр дахь үе шат. 2008 оны 10 дугаар сарын 1-ээс 2009 оны 9 дүгээр сарын 31-ний дотор хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

12.2.1. Нэг цэгийн үйлчилгээг нийслэлийн Хан-Уул, Налайх, Багануур болон Багахангай дүүрэгт байгуулна.

12.2.2 нэг цэгийн үйлчилгээг Булган, Баянхонгор, Мөрөн, Улиастай, Алтай, Улаангом, Ховд, Өлгий, Цэцэрлэг, Арвайхээр болон Хархорин хотод байгуулна.

12.2.3. "Нэг цэгийн үйлчилгээ"-ний эрх зүйн болон санхүүгийн орчинг боловсронгуй болгож дуусгана.

12.3. Хөтөлбөрийн гурав дахь үе шат, 2009 оны 10 дугаар сарын 1-ээс 2010 оны 9 дүгээр сарын 1-ний дотор хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

12.3.1. Нэг цэгийн үйлчилгээг суманд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг судалж, 1-2 суманд жишиг байдлаар зохион байгуулна.

12.3.2. нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

12.3.3. эрх зүйн болон санхүүгийн орчинг улам боловсронгуй болгон "Нэг цэгийн үйлчилгээ"-ний загварыг бататгана.

### Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

13. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

13.1. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцын болон үр дүнгийн тайлан, судалгаа;

13.2. дүүрэг, аймаг, суманд байгуулсан нэг цэгийн үйлчилгээний тоо, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний талаархи иргэдийн гомдол, саналын тоо, агуулга;

13.3. холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд судалгааны байгууллагаас өгсөн үнэлгээ, дүгнэлт;

13.4. нэг цэгийн үйлчилгээний талаар иргэд, аж ахуйн нэгжийн дунд явуулсан санал асуулгын дүн.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төрийн шагналт, эрдэмтэн, зохиолч Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойг 2008 онд тэмдэглэхээр тогтоосугай.

2. Ой тэмдэглэх ажлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Дарга:

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Дэд дарга:

-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч

Гишүүд

-Улсын үндэсний номын сангийн захирал;

-Монгол Улсын их сургуулийн захирал;

-Дорнод аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;

### Ой тэмдэглэх тухай

-Дорнод аймгийн Матад сумын Засаг дарга;

-Монголын зохиолчдын эвлэлийн дарга;

-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал;

-Монголын уран зохиолын академийн ерөнхийлөгч /тохиролцсоноор/;

-Дорнод аймгийн нутгийн зөвлөлийн дарга /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга.

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын дарга.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

### Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн

эмнэлгийн шүүх-шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн Шүүхийн шинжилгээний алба, нийслэлийн дүүрэг, Төмөр замын цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн газрын криминалистикийн шинжээч,

Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн шүүх эмнэлгийн шинжээч эмч нарыг нэгтгэж Нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн харьяанд тус тус байгуулсугай.

2. Дээрх байгууллагуудын криминалистикийн шинжээч, шүүх-шинжээч эмч, шинжээч эмч нарын орон тоо, төсөв болон криминалистикийн шинжээчдийн эзэмшиж, ашиглаж байгаа шинжилгээний аппарат, тоног төхөөрөмжийг тус тус балансаас балансад энэ оны 12 дугаар сарын 1-ний дотор багтаан Шүүхийн шинжилгээний албанд шилжүүлж, тухайн аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн лаборатори, ажлын контор, нэгдсэн эмнэлгийн задлан шинжилгээ, цогцос хадгалах өрөөг Шүүхийн шинжилгээний албыг ажлын болох хүртэл төлбөргүй эзэмшүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Шүүхийн шинжилгээний албаны дүрэм, орон тооны хязгаар, төлбөрт үйлчилгээ, урамшуулалт цалингийн журмыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай.

4. Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн зүгээс Шүүхийн шинжилгээний албыг шууд удирдлагаар хангаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж байх арга хэмжээ авч, тус албыг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, энэ ажилд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байхыг Эрүүл мэндийн сайд Д.Туяад тус тус үүрэг болгосугай.

5. Шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болгох асуудлыг судалж, саналаа энэ оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд тус тус даалгасугай.

6. Шүүхийн шинжилгээний албыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэшил, ур чадварыг нь дээшлүүлэх талаар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**М.ЭНХБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Д.ОДБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 279

Улаанбаатар  
хот

### Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

1. "Үндэсний хөтөлбөрийн хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 167 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны дүрэм"-д "Салбар хороо нь тухайн байгууллагын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ" гэсэн 2.17 дахь хэсэг нэмсүгэй.

2. Мөн дүрмийн 2.12-г "Яамны салбар хороо нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа агентлагийн, аймаг, нийслэлийн салбар хороо нь сум, дүүргийн салбар хорооны ажлыг уялдуулан зохицуулж, хамтарч ажиллана" гэсэн, 2.15-д "Яамны салбар хороо нь агентлагийн, аймаг, нийслэлийн салбар хороо нь сум, дүүргийн салбар хорооны тайлан, мэдээ

нэгтгэж ирүүлнэ." гэсэн, 5.1-д "Хорооноос баталсан хуваарийн дагуу хорооны төсвийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиран зарцуулна." гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

3. Мөн дүрмийн 2.4-ийн "тогтооно" гэснийг "батална" гэж, 2.15-ын "улирал бүр" гэснийг "хагас, бүтэн жилээр буюу 6 дугаар сарын 20, 12 дугаар сарын 20-ны дотор" гэж, мөн хэсгийн "Хороонд" гэснийг "Хорооны ажлын албанд" гэж, 4.1-ийн "тушаал" гэснийг "шийдвэр" гэж тус тус өөрчилсүгэй.

4. Мөн дүрмийн 4.1-ийн "хорооны төсвийг захиран зарцуулж," гэсэн хэсгийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**М.ЭНХБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Д.ОДБАЯР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь.

1. "Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг жилд 150.0 (нэг зуун тавин) сая төгрөгөөс доошгүй байхаар тооцож 2008 оноос эхлэн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Н.Баярсайханд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 265 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2007 оны 280 дугаар  
тогтоолын хавсралт

### ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН УРАН БҮТЭЭЛ ТУУРВИХАД ТӨРӨӨС САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад мэргэжлийн урлагийн байгууллага, уран бүтээлчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд энэ журмыг мөрдөнө.

1.2. Санхүүгийн дэмжлэг авахаар ирүүлсэн хүүхдэд зориулсан уран бүтээлийн төслийг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "Мэргэжлийн зөвлөл" гэх) нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

1.3. Мэргэжлийн зөвлөл нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтан, мэргэжлийн кино, драм, хөгжим, утга зохиол, ном хэвлэл, урлаг судлаачийн төлөөлөл бүхий долоон гишүүнтэй байна.

1.4. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### Хоёр. Санхүүжилтийн зориулалт

2.1. Санхүүгийн дэмжлэгийг хүүхдэд зориулсан дараахь уран бүтээлийг дэмжихэд зориулна:

2.1.1. уран сайхны болон баримтат, хүүхэддэй кино;

2.1.2. сонгодог болон үндэсний дуурь, бүжгийн жүжиг;

2.1.3. өөрийн орны болон гадаадын зохиолчдын жүжгийн найруулга;

2.1.4. драмын болон хүүхэддэй жүжиг;

2.1.5. хүүхдэд зориулсан дуу, найрал дуу, хөгжим болон концертын бүтээл;

2.1.6. циркийн хөтөлбөр.

2.1.7. хүүхдийн уран зохиолын болон танин мэдэхүйн ном;

2.1.8. хүүхдэд зориулсан хөгжмийн концертын зохиол болон цомнол.

#### Гурав. Бүтээлд тавигдах шаардлага

3.1. Санхүүгийн дэмжлэг хүссэн бүтээл нь дараахь шаардлагыг хангасан байна:

3.1.1. монголын үндэсний уламжлал, түүх, соёл, ёс заншлыг урлаг, уран сайхны өндөр түвшинд харуулсан;

3.1.2. хүүхдийн сонирхол, танин мэдэхүйн сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн ололтыг ойлгомжтой байдлаар харуулсан;

3.1.3. садар самуун, хүчирхийлэл болон мансууруулах бодис, алан хядлага зэрэг хуулиар хориглосон сөрөг үзэгдэл сурталчлаагүй байх

#### Дөрөв. Бүтээл шалгаруулалт

4.1. Тухайн жилд бүтээгдсэн уран бүтээлийг шалгаруулалтад оролцуулна

4.2. Шалгаруулалтыг 2 дугаар сар, 9 дүгээр сард тус тус зохион байгуулна.

4.3. Санхүүгийн дэмжлэг хүссэн нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн шалгаруулалтаас нэг сарын өмнө Мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ:

4.3.1. бүтээлийн танилцуулга (дэлгэрэнгүй);

4.3.2. бүтээлийн төсөл;

4.3.3. санхүүгийн тооцоо;

4.3.4. эрх бүхий болон мэргэжлийн байгууллагын тодорхойлолт.

4.4. Бүтээлийг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн шалгаруулна.

4.5. Бүтээл нь санхүүжилт авахаар шалгарсан тохиолдолд зохиогчийн эрхтэй холбоотой бусад асуудлыг хэрхэн зохицуулах талаар гэрээний төслийг хавсаргасан байна.

#### Тав. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

5.1. Мэргэжлийн зөвлөл нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. тухайн уран бүтээлийн төсөл нь энэ журмын 3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоож, тодорхой үндэслэл бүхий дүгнэлт гаргах;

5.1.2. уран бүтээлийн цар хүрээ, ач холбогдлыг харгалзан санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох.

5.2. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн гишүүдийн ирц 80-аас дээш хувь бүрдсэн тохиолдолд хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

5.3. Зөвлөлийн гаргасан дүгнэлтэд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.4. Мэргэжлийн зөвлөлийн гишүүний төсөл нь зөвлөлөөр хэлэлцэгдэж байгаа бол тухайн гишүүний хуралдаанд оролцуулахгүй.

5.5. Мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай шийдвэр гаргана.

5.6. Бүтээлийг дэмжихэд олгосон хөрөнгийн нэг хувьтай тэнцэх хэсгийг түүнийг сурталчлах, зөвлөлийн гишүүдийг урамшуулахад зарцуулна.

5.7. Хүүхдийн уран бүтээлд зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

#### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 110, 111 ДҮГЭЭР ЗҮЙЛҮҮДИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

**1. Эрүүгийн хуулийн (цаашид хуулийн гэх) 110 дугаар зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.**

1.1 Хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д заасан "...нэр төр" гэж тухайн хүний хувийн болон өс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмжийг хэлнэ.

1.2 Мөн зүйл, хэсэгт заасан "...алдар хүнд..." гэдэгт бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно.

1.3 Мөн зүйл, хэсэгт заасан "...доромжлох..." гэдэгт нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон өс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдлийг хэлнэ.

Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ.

1.4 Мөн зүйл, хэсэгт заасан "...олон нийт..." гэдэг нь нийгмийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт учир тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгох нөхцлийн хувьд заавал хоёр буюу түүнээс олон хүний дэргэд доромжилсон байхыг шаардахгүй бөгөөд бусдын нэр төр, алдар хүндийг нэг хүний ч дэргэд гутаасан байж болно.

1.5 Мөн зүйл, хэсэгт заасан "...хэвлэл мэдээллийн хэрэгсэл..." гэдгийг Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар ойлгоно.

1.6 Доромжлох нь хэлбэрийн бүрэлдхүүнтэй гэмт хэрэг тул үйлдэл хийснээр төгссөн гэмт хэрэгт тооцогдоно.

**2. Эрүүгийн хуулийн (цаашид хуулийн гэх) 111 дүгээр зүйлийн зарим заалтыг дор дурдсанээр тайлбарласугай.**

2.1 Хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д заасан "... нэр төр, алдар хүнд..." гэдгийг энэ тогтоолын 1.1, 1.2-т зааснаар тус тус ойлгоно.

2.2 Мөн зүйл, хэсэгт заасан "...гутаах зорилго..." гэж өс хоноон санах, үзэн ядах, уур хорслоо тайлах, агаархах, эр эмийн хардлага зэрэг аргаг санаагаа хэрэгжүүлэх гэсэн хувийн сэдэлтийг хэлнэ.

2.3 Мөн зүйл, хэсэгт заасан "...худал гүжирдлэг..." гэдэгт илт худал мэдээлэл, баримт сэлтийг ойлгоно.

2.4 Мөн зүйлийн 111.2-т заасан "...хэвлэл, мэдээллийн хэрэгсэл..." гэдгийг энэ тогтоолын 1.5-д зааснаар ойлгож хэрэглэнэ.

2.5 Мөн зүйл, хэсэгт заасан "...**нийтэд тараасан...**" гэж худал гүжирдлэгийг нэг буюу түүнээс дээш хүнд түгээсэн байхыг хэлнэ.

2.6 Мөн зүйл, хэсэгт заасан "...**урьд ял шийтгүүлсэн ...**" гэдэгт доромжлох, гүтгэх гэмт хэргээг өмнө нь ял шийтгүүлсний дараа Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2, 78.3-т заасан ялгүй болох хугацаа өнгөрөөгүй, эсхүл ялгүйд тооцогдоогүй байхад энэ төрлийн гэмт хэргийг шинээр үйлдсэнйг ойлгоно.

Харин Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа өнгөрсөн, мөн зүйлийн 78.3-т заасан үндэслэлээр ялгүйд тооцогдсоны дараа доромжлох, гүтгэх гэмт хэргийг шинээр үйлдсэн бол урьд ял шийтгүүлсэнд тооцохгүй.

2.7 Мөн зүйлийн 111.3-т заасан "...**хүнд хор уршиг учирсан...**" гэдэгт гүтгэгдсэн этгээд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнд холбогдон мөрдөн шалгагдсан, цагдан хоригдсон, ял шийтгүүлсэн, ял эдэлсэн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирал учирсан, захиргааны санаачлагаар ажлаас халагдсан, гэрлэлтийг цуцалсан, өөрөө болон түүний гэр бүлийн гишүүд нь сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, бие эрхтэнд нь хүнд гэмтэл учирсан буюу амь нас хохирсон зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.

2.8. Гүтгэх гэмт хэргийн хохирогч нь эрх зүйн чадамжаас үл хамааран эрх зүйн чадвар бүхий иргэн байна. Харин нас барсан хүнийг гүтгэсэн тохиолдолд Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1 - 520.3-т заасан хууль ёсны өвлөгч нь хохирогч байж болно.

2.9. Гүтгэх нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул үйлдэл хийснээр төгссөн гэмт хэрэгт тооцогдоно.

**3. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх талаар.**

3.1. Хүний хувийн нууцыг задруулах замаар доромжилсон бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, Эрүүгийн хуулийн 110, 136 дугаар зүйлээр давхар зүйлчилнэ.

3.2. Доромжлох болон гүтгэх гэмт хэргийг үйлдэхдээ бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлсэн бол Эрүүгийн хуулийн 110, 111, 149

дүгээр зүйлээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3.3. Доромжлох гэмт хэрэг нь тодорхой хүний эсрэг чиглэсэн, түүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байдаг бол танхайрах гэмт хэрэг нь олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн байдгаараа ялгагдана.

Танхайрах гэмт хэргийн явцад хүний нэр төр, алдар хүндийг доромжилсон бол Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн аль тохирох хэсгээр зүйлчилнэ.

3.4. Доромжлох нь тодорхой албан тушаал эрхэлж байгаатай нь буюу хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгтэй нь холбогдуулах бус зөвхөн хувь хүний эсрэг чиглэсэн байдаг шинжээрээ Эрүүгийн хуулийн 231 дүгээр зүйлд заасан "Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох" гэмт хэргээс ялгагдана.

3.5. Гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь хүний нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн шууд санаатай байдаг бол Эрүүгийн хуулийн 252 дугаар зүйлд заасан "Зориуд худал мэдээлэх" гэмт хэрэг үйлдсэн этгээд нь бусдад хууль бусаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилготой байдгаар ялгагдана.

3.6. Доромжлох нь бодит байдалд нийцсэн байж болдгоороо гүтгэх гэмт хэргээс ялгагдах боловч үг үйлдлийг хийснээр хүний нэр төр, алдар хүнд гутаагддаг учир гэмт хэрэгт тооцогдоно.

3.7. Доромжилсон, эсхүл гүтгэсэн үйлдэл нь энэ хоёр гэмт хэргийн аль алиных нь шинжийг агуулж байгаа бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, давхар зүйлчилнэ.

3.8. Доромжлох гэмт хэргийн объект нь тухайн хүний нэр төр, алдар хүнд байдаг тул хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан аливаа үйлдлийг доромжлох гэмт хэрэгт тооцохгүй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

ШҮҮГЧ

Б.ДОРЖГОТОВ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

**Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар**

Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгох, танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн зарим гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн

тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь.

**1. Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.**  
**1.1 "Нийгмийн хэв журам"** гэдэгт нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг ойлгоно.

Энэхүү хэм хэмжээг хууль тогтоомж, зан заншил, ёс суртахууны шаардлагын алинаар нь ч тогтоосон байж болно.

**1.2 "Нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн"** гэж хүний халдашгүй, чөлөөтэй байх, амьд явах, амрах, хөдөлмөрлөх, сурах, амгалан тайван амьдрах талаар нийгэмд тогтож хэвшсэн ёс журмыг зөрчиж, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, олон нийтийг хамарсан арга хэмжээг тасалдуулах, хамтын аж байдлын ёс горимд харшилсан санаатай үйлдэл хийхийг хэлнэ.

**1.3 "Олон нийт"** гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.

**"Олон нийтийг илтэд үл хүндэтгэх"** гэдэгт хууль тогтоомжоор тодорхойлсон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ, түүнчлэн үндэсний зан заншил, уламжлал, ёс суртахууны шаардлагыг зөрчсөн, тэдгээрийг илэрхий үл ойшоосон үйлдэл хийхийг ойлгоно.

**1.4 "Хүч хэрэглэх"** гэж бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг хэлнэ.

**"Хүч хэрэглэхээр заналхийлэх"** гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй үйлдэлд илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно.

**1.5 "Догшин авирлаж"** гэж олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн үйлдлийг ичгүүр сонжуургүй авирлаж, харгис хэргийг аргаар, зориуд удал үргэлжлүүлэн хийсэн байхыг хэлнэ.

Түүнчлэн танхайрах явцдаа бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан, эд хөрөнгийг устгасан, гэмтээсэн зэргийг догшин авирласан гэж үзнэ.

**1.6 "Нийгмийн хэв журм хамгаалах үүргээ биелүүлэх"** гэж хүмүүс олноор цугларсан газар болон гудамж, талбайд хэв журам сахиулах, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

**"Нийгмийн хэв журмыг хамгаалах үүргээ биелүүлж буй цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэний эсэргүүцэл"** гэдэгт танхайрах үйлдлийг албаны

болон иргэний үүргийн хувьд хориглон зогсоох талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн шаардлагыг үл ойшоох, биелүүлэхгүй байх, тэдгээрийн эсрэг бие махбодийн, эсхүл сэтгэл санааны аливаа хүчирхийлэл үйлдэхийг ойлгоно.

Эсэргүүцэх нь хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх хэлбэрийн алинаар нь ч илэрхийлэгдэх бөгөөд энэ үед эсэргүүцлийн ямар ч үйлдэл хийгдсэн байж болно.

**"Таслан зогсоох"** гэж гэмт үйлдлийг хориглон зогсооход чиглэсэн идэвхтэй ажиллагааг хэлнэ.

Харин гэмт этгээдийг гуйх, ятгах, ухуулах болон сургамжлах зэргийг танхайрах үйлдлийг таслан зогсоосон гэж үзэхгүй.

Танхайрах үйлдэл таслан зогсоогдсон буюу төгссөний дараа гэмт этгээд шаардлага тавьсан иргэнийг эсэргүүцсэн нь танхайрах гэмт хэргийн хүндрүүлэх шинж болохгүй тул энэ тохиолдолд тухайн үйлдлийг хүний амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргийн аль тохирох зүйл, хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Түүнчлэн танхайрахаас өмнө буюу уг үйлдэл таслан зогсоогдсон эсхүл төгссөний дараа цагдаагийн ажилтан, төрийн хийгээд олон нийтийн төлөөлөгчийг эсэргүүцсэн бол захиргааны журмын эсрэг болон танхайрах гэмт хэргээр давхар зүйлчилнэ.

**1.7 "Урьд энэ хэрэгт шийтгүүлсэн"** гэдэгт танхайрах гэмт хэрэгт өмнө нь ял шийтгүүлсний дараа Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа өнгөрөөгүй, эсхүл мөн зүйлийн 78.3-т зааснаар ялгүйд тооцогдоогүй байхад танхайрах гэмт хэргийг шинээр үйлдсэнийг ойлгоно.

Харин Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа өнгөрсөн, мөн зүйлийн 78.3-т заасан үндэслэлээр ялгүйд тооцогдсоны дараа танхайрах гэмт хэрэг шинээр үйлдсэн бол урьд ял шийтгүүлсэнд тооцогдохгүй.

**2. Танхайрах гэмт хэргийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс ялган зүйлчлэх талаар**

2.1 Танхайрах гэмт хэрэг нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс гэмт хэргийн сэдэлт, санаа зорилго зэрэг субъектив талын шинж, мөн үйлдэл, үр дагавар зэрэг объектив талын шинжээр ялгагдана.

**"Танхайрах гэмт хэрэг"** нь гэмт этгээд олон нийтийг илтэд үл хүндэтгэн, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчихдөө нийгэмд тогтсон эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, уламжлагдан ирсэн зан заншлыг үл тоомсорлон, өөрийн ичгүүр сонжуургүй, догшин зан авир, бүдүүлэг үйлдлээ бусдын анхаарлын төвд байлгахыг эрмэлзэх, ямар ч шалтгаангүй, эсхүл ялимгүй зүйлээр шалтгаан хэрүүл маргаан өдөх, агсам тавих, элдвээр доромжлох, айлган сүрдүүлэх, басамжлах,

дарамтлах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэх эсрэг үйлдлээр илэрнэ.

Харин тодорхой сэдэлтэй, тухайлбал хувийн таарамжгүй харьцаа, эр эмийн хардлага, хохирогчийн зүй бус ажиллагаа зэргээс үүдэн өөр хоорондоо маргалдсан, зодолдсон, доромжилсон, бие махбодид нь гэмтэл учруулсан нь олон нийтийг илтэд хүндэтгэн үзээгүй буюу нийгмийн хэв журмыг бүдүүглээр зөрчөөгүй байвал хүний амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.2 Танхайрах үйлдэл нь урьдчилан төлөвлөөгүй, гэнэт үүссэн шинжтэй, эмх замбараагүй байдаг бол хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг нь ихэвчлэн тооцож төлөвлөсөн, тодорхой үр дүнд хүрэхийг эрмэлзэж, үйлдлээ өөрөө хянаж, хэссэн үр дүндээ хүрээд үйлдлээ зогсоодог эсрэг онцлогтойг хэргийг зүйлчлэхдээ анхаарвал зохино.

2.3 Танхайрах гэмт хэргийг үйлдэх явцад бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, хүнийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91, 96 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр зүйлчилнэ.

2.4 Танхайрах гэмт хэргийн эсрэг хийсэн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 40, 41 дүгээр зүйлд заасан аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын шинжгүй бол гэмт хэргийн улмаас учирсан үр дагаврыг харгалзан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

**3. Танхайрах гэмт хэргийг бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх гэмт хэргээс ялгаж зүйлчлэх талаар**

3.1 Танхайрах гэмт хэрэг нь нэг болон хэд хэдэн объектод халддаг учраас уг үйлдэлтэй ямар ч холбоогүй хөндлөнгийн этгээд хохирох, мөн бусдын эд хөрөнгийг санаатайгаар ямар ч шалтаг, шалтгаангүйгээр устгах буюу гэмтээх үр дагавар бий болдог тул танхайрах явцад бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол Эрүүгийн хуулийн 153, 181 дүгээр зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилнэ.

3.2 Хувийн эд хөрөнгөө санаатайгаар устгах, гэмтээх нь танхайрах гэмт хэргийн шинжтэй байвал зөвхөн танхайрах гэмт хэргээр зүйлчилнэ.

**4. Танхайрах гэмт хэргийг захиргааны журмын эсрэг гэмт хэргээс ялгаж зүйлчлэх талаар**

4.1 Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.2.3-т заасан гэмт хэргийн халдлагын объект нь нийгмийн аюулгүй байдал бол мөн хуулийн 230, 231,

232 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объект нь захиргааны журам байдгаараа ялгагдана.

4.2 Нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэний амь бие, эрүүл мэндэд гэмтэл учруулахгүйгээр хүч хэрэглэн танхайрсан бол Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн тохирох хэсгээр зүйлчлэх бөгөөд захиргааны журмын эсрэг гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй.

**5. Танхайрах гэмт хэргийг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан танхайрах зөрчлөөс ялгаж зүйлчлэх талаар**

5.1 Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан танхайрах зөрчил нь үйлдэгдсэн арга, орон зай болон бусад шинжээрээ танхайрах гэмт хэргтэй төстэй боловч бусдыг хүч хэрэглэн зодсон, бие махбодид нь гэмтэл учруулсан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олон нийтийн чанартай арга хэмжээг тасалдуулсан, эд хөрөнгийг санаатайгаар устгаж, гэмтээсэн эсрэг үр дагавар бий болгодоггүй, нийгмийн хор аюулаараа бага байдгаараа танхайрах гэмт хэргээс ялгагдана.

5.2 Танхайрах гэмт хэргийг танхайрах зөрчлөөс ялгахын тулд зөрчил гаргасан газар, орон зай, арга, түүний өрнөлт, үр дагавар эсрэг нөхцөл байдлуудыг харгалзан үзвэл зохино.

**6. Бусад асуудлын талаар**

6.1 Насанд хүрээгүй хүнийг танхайрах гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 114, 181 дүгээр зүйлийг давхар хэрэглэж, нийлмэл гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6.2 Танхайрах гэмт хэргийг үйлдэх явцад бусдын эд хөрөнгийг хулгайлсан, булаасан, дээрэмдсэн бол өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн аль тохирох зүйл, хэсгээр давхар зүйлчилнэ.

6.3 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчиж танхайрсан бол Эрүүгийн хуулийн 181, 215 дүгээр зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6.4 Танхайрах гэмт хэргийг үйлдэх явцад хэрэглэсэн "зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолд тайлбарласнаар ойлгож хэрэглэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Б.ДОРЖГОТОВ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар - 12  
Төрийн ордон

☎ 255058  
Индекс: 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5